



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 41 (374)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Номын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны арваннэгдүгээр сарын 3 №41 (374)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|-----|
| 402. | Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 744 |
| 403. | Монгол Улсын 2004 оны төсвийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 745 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 404. | Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн
албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 154 | 749 |
| 405. | Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн
албан тушаалд томилох тухай | Дугаар 155 | 750 |
| 406. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд
томилох тухай | Дугаар 156 | 750 |
| 407. | Канад Улсын иргэн О' Нейлийг "Найрамдал"
медалиар шагнах тухай | Дугаар 158 | 751 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 408. | Зардлын дундаж норматив,
жишиг батлах тухай | Дугаар 187 | 751 |
| 409. | Хэлэлцээр батлах тухай | Дугаар 190 | 754 |
| 410. | Номын сангийн талаар авах
зарим арга хэмжээний тухай | Дугаар 196 | 754 |

2004 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17.2, 19.1, 19.4-т дараахь заалтууд нэмсүгэй:

"1/ 17.2.3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо:

- боловсрол;
- соёл, урлаг;
- шинжлэх ухаан;
- ард түмний түүх, соёл, оюуны өвийг сэргээх, хамгаалах талаархи бодлого;
- монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, соёл, урлаг, ёс заншлын талаар төрөөс баримтлах бодлого.

2/ 17.2.4. Дэд бүтцийн байнгын хороо:

- барилга, хот байгуулалт;
- түлш, эрчим хүч;
- зам тээвэр, шуудан;
- орон сууц, нийтийн аж ахуй;
- аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил.

3/ 17.2.5. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн байнгын хороо:

- мэдээлэл, технологийн хөгжил;
- харилцаа холбоо;
- хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- техник, технологийн шинэчлэл.

4/ 17.2.10. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:

- газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого;
- хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал;
- хөдөөгийн хөгжлийн бодлого;
- хөдөөг хөгжүүлэх бодлоготой холбоотойгоор хэрэгжих гадаад орны болон олон улсын байгууллагын зээл тусламжийн гэрээ;
- мал аж ахуйн бодлого;
- малын даатгал болон малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах.

5/ 19.1.5. Эдийн засгийн байнгын хороонд:

1/ Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн.

6/ 19.4.6. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо:

- жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих;
- жижиг, дунд үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн бодлого, зохицуулалт."

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"16.2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороодтой байна:

- 16.2.1. Аюулгүй байдал, гадаад бодлогын;
- 16.2.2. Байгаль орчны;
- 16.2.3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны;
- 16.2.4. Дэд бүтцийн;
- 16.2.5. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн;
- 16.2.6. Нийгмийн бодлогын;
- 16.2.7. Төрийн байгуулалтын;
- 16.2.8. Төсвийн;
- 16.2.9. Хууль зүйн;
- 16.2.10. Хүнс, хөдөө аж ахуйн;
- 16.2.11. Эдийн засгийн."

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17.2.2-ын "Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн" гэснийг "Байгаль орчны" гэж; 17.2.7-ийн "бүсчилсэн хөгжил, барилга, хот байгуулалт" гэснийг "бүсчилсэн хөгжил" гэж; мөн заалтын "үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт, төхник, технологийн шинэчлэл" гэснийг "үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт" гэж; 28.1-ийн "хоёр" гэснийг "гурван" гэж; 17.2.3, 17.2.4, 17.2.5, 17.2.6 дахь заалтын дугаарыг "17.2.6, 17.2.7, 17.2.8, 17.2.9" гэж; 17.2.7 дахь заалтын дугаарыг "17.2.11" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16.5-ын "албан бичгийн" гэснийг;

17.2.2-ын "-газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого; -хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал; -хөдөөгийн хөгжлийн бодлого; -хөдөөг хөгжүүлэх бодлоготой холбоотойгоор хэрэгжих гадаад орны болон олон улсын байгууллагын зээл тусламжийн гэрээ; -мал аж ахуйн бодлого; -малын даатгал болон малын өвчний асуудал;" гэснийг; 17.2.3-ын "-боловсрол; -соёл, урлаг; -шинжлэх ухаан, мэдээлэл, технологийн хөгжил; -ард түмний түүх, соёл, оюуны өвийг сэргээх, хамгаалах талаархи бодлого; -монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, соёл, урлаг, ёс заншлын талаар

төрөөс баримтлах бодлого;" гэснийг; 17.2.4-ийн "-хэвлэл, мэдээллийн хэрэгсэл;" гэснийг; 17.2.7-гийн "-дэд бүтцийн хөгжлийн бодлого;" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2004 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хуулийн 3, 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ "3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2004 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн орлогын хэмжээг 613,701,547.4 мянган төгрөгөөр баталсугай."

2/ "4 дүгээр зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 699,102,676.2 мянган төгрөгөөр баталсугай."

3/ "5 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2004 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харьяа байгууллагууд, бусад байгууллагуудын төвлөрүүлэх орлогын дүнг дараахь байдлаар баталсугай:

/мянган төгрөгөөр/

5.1.	Монгол Улсын Ерөнхий сайд	25,798,903.7
5.1.1.	Төрийн өмчийн хороо	14,133,058.9
5.1.2.	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар	8,000,000.0
5.1.3	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	3,665,844.8
5.2.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	806,815.9
5.2.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	806,815.9
5.3.	Гадаад хэргийн сайд	4,419,311.1
5.3.1.	улсын тэмдэгтийн хураамж	3,731,422.6
5.3.2.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	687,888.5
5.4.	Сангийн сайд	471,524,614.4
5.4.1.	Үндэсний татварын ерөнхий газар	212,666,162.7
5.4.2.	Улсын гаалийн ерөнхий газар	244,773,700.0
5.4.3.	Төрийн сан	14,084,751.7

5.5.	Хууль зүй, дотоод хэргийн сайд		1,410,455.8
5.5.1.	Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар		0.0
5.5.2.	Иргэний бүртгэл мэдээллийн төв		55,650.0
5.5.3.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		1,354,805.8
5.6.	Байгаль орчны сайд		2,177,191.7
5.6.1.	Байгаль орчныг хамгаалах алба		2,058,832.4
5.6.2.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		118,359.3
5.7.	Батлан хамгаалахын сайд		566,896.1
5.7.1	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		566,896.1
5.8.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд		25,084,384.9
5.8.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		25,084,384.9
5.9.	Дэд бүтцийн сайд		94,770.5
5.9.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		94,770.5
5.10.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд		108,946,666.0
5.10.1	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар		106,721,186.0
5.10.2.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		2,225,480.0
5.11.	Үйлдвэр, худалдааны сайд		6,896,562.5
5.11.1	Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар		6,887,562.5
5.11.2.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		9,000.0
5.12.	Хүнс, хөдөө аж ахуйн сайд		108,213.8
5.12.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		108,213.8
5.13.	Эрүүл мэндийн сайд		2,921,353.0
5.13.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		2,921,353.0
5.14.	Үндэсний статистикийн газрын дарга		3,500.0
5.14.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		3,500.0
5.15.	Монгол банк		5,000,000.0
5.16.	Түлш, эрчим хүчний сайд		4,000.0
5.16.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		4,000.0
5.17.	Зам тээвэр, аялал жуулчлалын сайд		14,247,500.0
5.17.1.	Иргэний нисэхийн ерөнхий газар		13,435,000.0
5.17.2.	Улаанбаатар төмөр замын Хэрэг эрхлэх газар		812,500.0



5.18.	Монгол Улсын шадар сайд	173,516.9
5.18.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	173,516.9
5.19.	Улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	2,000.0
5.19.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	2,000.0
5.20.	Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн сайд	87,080.0
5.20.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	87,080.0
5.21.	Барилга, хот байгуулалтын сайд	1,375,000.0
5.21.1.	харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	1,375,000.0

4/ "6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдад дор дурдсанаар төсөв зарцуулах эрхийг олгосугай:

/мянган төгрөгөөр/

6.1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар	809,102.2
6.2.	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга	2,915,566.6
6.3.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	89,407.9
6.4.	Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч	251,902.6
6.5.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	2,513,654.2
6.6.	Улсын Ерөнхий прокурор	1,915,649.0
6.7.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	61,074.2
6.8.	Монгол Улсын Ерөнхий сайд	11,162,420.1
6.9.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	5,255,224.3
6.10.	Гадаад хэргийн сайд	8,480,750.1
6.11.	Сангийн сайд	150,768,402.3
6.12.	Хууль зүй, дотоод хэргийн сайд	43,806,819.5
6.13.	Байгаль орчны сайд	5,210,946.9
6.14.	Батлан хамгаалахын сайд	19,893,393.8
6.15.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	150,659,700.2
6.16.	Дэд бүтцийн сайд	468,393.5

6.17.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	149,962,414.9
6.18.	Үйлдвэр, худалдааны сайд	2,989,655.0
6.19.	Хүнс, хөдөө аж ахуйн сайд	10,048,342.0
6.20.	Эрүүл мэндийн сайд	78,895,729.6
6.21.	Төрийн албаны зөвлөлийн дарга	134,558.3
6.22.	Сонгуулийн ерөнхий хороо	1,048,959.6
6.23.	Хүний эрхийн үндэсний комиссын дарга	74,236.7
6.24.	Үндэсний ерөнхий аудитор	166,528.0
6.25.	Үнэт цаасны хорооны дарга	93,908.2
6.26.	Үндэсний статистикийн газрын дарга	616,628.8
6.27.	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	1,055,151.4
6.28.	Барилга, хот байгуулалтын сайд	3,098,416.9
6.29.	Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд	44,149,597.3
6.30.	Түлш, эрчим хүчний сайд	24,698,241.5
6.31.	Монгол Улсын шадар сайд	467,325.7
6.32.	Улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	3,900,275.1
6.33.	Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн сайд	9,442,232.9."

5/ "7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 оны төсвийн жилд дотоод эх үүсвэрээс хийх нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 52,896,300.0 мянган төгрөгөөр, үүнээс шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөвт өртгийг 24,798,800.0 мянган төгрөгөөр, үүнээс 2004 онд санхүүжүүлэх объектын төсөвт өртгийг 5,803,800.0 мянган төгрөгөөр, гадаад

эх үүсвэрээр гүйцэтгэх авто замын байгууламжийн хөрөнгө оруулалтын хэмжээг 25,985,500.0 мянган төгрөгөөр баталсугай."

6/ "8 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг дор дурдсанаар баталсугай:

	/мянган төгрөгөөр/
Нийт дүн	8,471,149.2
8.1. Архангай	341,744.8
8.2. Баян-Өлгий	361,188.8
8.3. Баянхонгор	624,994.4
8.4. Булган	387,196.0
8.5. Говь-Алтай	765,976.2
8.6. Дорнод	166,526.3
8.7. Дундговь	454,299.3
8.8. Завхан	651,225.3
8.9. Өвөрхангай	547,128.7
8.10. Өмнөговь	474,120.1
8.11. Сүхбаатар	383,059.8
8.12. Сэлэнгэ	429,590.0
8.13. Төв	819,606.8
8.14. Увс	633,645.2
8.15. Ховд	567,200.5
8.16. Хөвсгөл	296,563.0
8.17. Хэнтий	389,848.3
8.18. Говьсүмбэр	177,235.7

7/ "9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн төсвөөс Улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

	/мянган төгрөгөөр/
Нийт дүн	
9.1. Дорноговь	
9.2. Дархан-Уул	
9.3. Улаанбаатар	
9.4. Орхон	

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Батчулууны Сосорбарамыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Бат-Очирын Бямбасүрэнг Ховд

аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Тумагийн Цэцэгмааг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, өөрөө хүсэлт гаргасан Чимэдбалдирийн Баасанжавыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Замбын Минжирмааг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох санд хүрсэн Цагнямын Балжиннямьг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр

шүүхийн шүүгчийн, ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь дууссан тул Ядамсүрэнгийн Туулыг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 10 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн
албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Бат-Очирын Бямбасүрэнг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Тумагийн Цэцэгмааг Ховд аймаг дахь сум дундын

1 дүгээр шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Цэрэндоржийн Жамбалсүрэнг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 10 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан
тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Батчулууны Сосорбарамыг Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгчийн, Ноопын Болормаа, Аюушийн Отгончимэг, Дагийшаравын Бямбасүрэн нарыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дүйсөнбекийн Көбөшийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цэрэндашийн Цэрэндуламыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дашийн Цагаандарийг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Батнасангийн Мөнхжаргалыг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Батдолгорын Энхбаатарыг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Эрдэнэ-Очирын Болормааг Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн, Цогт-Счирик: Отгонцэцэгийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн,

Доржсүрэнгийн Батбаясгалан, Бадамдоржийн Ариунбаяр нарыг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Ванд-Очирын Цэцэнбилэгийг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Рашээвэгийн Мөнх-Эрдэнийг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Гөлгөөгийн Давааринчинг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчийн, Баасайн Дима, Буянцогийн Цолмон нарыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Гоошоохүүгийн Даваадоржийг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, Энэбишийн Золзаяаг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, Дэмбэрэлийн Батбаатар, Дамдины Ганзориг нарыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 10 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Канад Улсын иргэн О'Нейлийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Канад Улсын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, ард түмнүүдийн харилцан ойлголцлыг бэхжүүлэх, Канадын Олон улсын хөгжлийн судалгааны үйл ажиллагааг Монгол Улсад эхлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Канад Улсын Олон улсын хөгжлийн судалгааны

төвийн Ерөнхийлөгч, хатагтай Маурийн О'Нейлийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 187

Улаанбаатар
хот

Зардлын дундаж норматив, жишиг батлах тухай

Боловсролын тухай хуулийн 40.3, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 25.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 1 дүгээр хавсралт, төрийн өмчийн их, дээд сургууль, коллежид дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Цэцэрлэгийн нэг хүүхдэд улсын төсвөөс олгох хоолны зардлын хэмжээг жилд 36000 (гучин зургаан мянган) төгрөгөөр тогтоосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны (8 дугаар анги төгсөөд элссэн) ангийн дотуур байранд амьдрах нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 110950 (нэг зуун арван мянга есөн зуун тавин) төгрөгөөр тогтоож улсын төсвөөс санхүүжүүлж байсугай.

4. Дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг баримтлан сургуулийнхаа сургалтын төлбөрийн хэмжээг тогтоон мөрдөхийг төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн захирал, удирдах зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зардлын норматив, жишиг батлах тухай" Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 176 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

А.ЦАНЖИД

Засгийн газрын 2004 оны 187 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ

/мянган төгрөг/

№	Бүс нутаг	Аймаг, хот	Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал	Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал			Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардал
				Бага анги	Дунд анги	Ахлах анги	
1	Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	125.9	79.1	98.4	105.6	183.3
				76.6	95.2	102.1	
2	Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	119.2	74.4	90.7	100.4	175.9
3	Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул 8. Улаанбаатар	118.5	73.9	91.6	99.8	174.7
4	Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	120.1	74.7	92.5	100.7	179.4

Тайлбар: 1. Дээрх хувьсах зардлын хэмжээнд цалингийн сангийн эзлэх хувь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 73.2, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 55.0 байна.

2. Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дүнд хоолны зардал ороогүй болно.

Засгийн газрын 2004 оны 187 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД ДЭЭД
БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ
СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ЖИШИГ**

№	Сургуулийн нэр	Зардлын жишиг /мянган төгрөг/
1	Монгол улсын их сургууль	310.0
2	Боловсролын их сургууль	285.0
3	Хөдөө аж ахуйн их сургууль	285.0
4	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль	330.0
5	Шинжлэх ухаан, технологийн их сургууль	310.0
6	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	295.0
7	Соёл урлагийн их сургууль	340.0
8	Монгол улсын их сургуулийн Ховд дахь салбар	285.0
9	Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль	255.0
10	Дүрслэх урлагийн дээд сургууль	315.0
11	Сүхбаатар аймаг дахь ШУТИС-ийн салбар	230.0
12	Архангай аймаг дахь Багшийн коллеж	210.0
13	Баян-Өлгий аймаг дахь Багш-соёлын сургууль	210.0
14	Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны коллеж	245.0
15	Дорноговь аймаг дахь Анагаах ухааны коллеж	255.0
16	Дорнод аймаг дахь Багшийн коллеж	230.0
17	Завхан аймаг дахь Эдийн засгийн коллеж	245.0
18	Дархан-Уул аймаг дахь Ургамал, газар тариалангийн хүрээлэн	275.0
19	Дархан-Уул аймаг дахь Техникийн коллеж	220.0
20	Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны коллеж	220.0
21	ЭМШУИС-ийн Сувилахуйн сургууль	210.0
22	Улаанбаатар дахь Соёлын коллеж	275.0
23	Дизайн урлагийн коллеж	275.0
24	Хөгжим бүжгийн коллеж	220.0
25	Дорнод аймаг дахь Хөдөө аж ахуйн хүрээлэн	180.0
26	Барилгын коллеж	180.0
27	Техник технологийн коллеж	180.0
28	Өвөрхангай аймаг дахь ШУТИС-ийн салбар	220.0
29	Улаангом коллеж	220.0
30	Ховд аймаг дахь Хөдөө аж ахуйн хүрээлэн	220.0
31	Үйлдвэр, үйлчилгээний сургууль	220.0
32	Хүнсний технологийн коллеж	220.0
33	Монгол-Солонгосын хамтарсан коллеж	220.0

Тайлбар: 1. Энэ жишиг нь бакалаврын боловсрол олгоход мөрдөх бөгөөд дипломын боловсрол олгоход энэхүү жишгээс 20 хувиар бага, магистрын болон докторын сургалтад 20 хувиар их байхаар бодон Сургалтын төрийн сангаас зээл, тусламж олгоно.

2. Төрийн өмчийн бус их, дээд сургуулийн суралцагчдад Сургалтын төрийн сангаас олгох зээл, буцалтгүй тусламж, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг 252.0 мянган төгрөгөөр, коллежид 210.0 мянган төгрөгөөр тооцож олгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг баталсугай.

2004 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ДЭД БҮТЦИЙН
САЙД

Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Номын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

төсвийн багцаас, 2005 оноос жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт үүрэг болгосугай.

1.Улсын төв номын санг бичгийн үнэт дурсгалыг хадгалах, хамгаалах, номын сангуудыг мэргэжил-арга зүй, мэдээллээр хангах, ном, хэвлэлийн нэгдсэн сан байгуулж үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий "Монгол Улсын Үндэсний номын сан", хүүхэд, залуучуудыг ном, хэвлэл болон мэдээллээр хангах, тэдний мэдлэг, оюуны эрэлт хэрэгцээнд зориулсан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий "Хүүхдийн номын ордон" гэсэн бие даасан төсөвт байгууллага болгон 2004 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн өөрчлөн зохион байгуулсугай.

3.Монгол Улсын Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордны бүтэц, дүрмийг баталж мөрдүүлэх, үйл ажиллагаанд нь мэргэжлийн хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

2.Монгол Улсын Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордонд 2004 онд шаардагдах зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

А.ЦАНЖИД

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12,
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329187
Хэвлэлийн хуудас 1.5